

## ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.06.29

Улаанбаатар хот

Экологийн цагдаагийн албанаас энэ оны эхний хагас жилд Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр**

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах тухай” А/65 дугаар тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгүүдээс тус албанд хамааралтай 44 баримт бичгийн 65 зүйл, заалтыг хяналтад авч, эхний хагас жилийн байдлаар нийт 36 бодлогын баримт бичгийн 56 зүйл заалтын биелэлт, үр дүнг тооцон холбогдох газарт тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Алба байгуулагдсанаас хойших хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 01/156 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн, 01/163 дугаар албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын, 01/164 дүгээр албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайдад тус тус хүргүүлсэн.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) 2019 оны 10 дугаар сард Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалтад оруулсантай холбогдуулан Монгол Улс энэ оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Ази номхон далайн Хамтарсан бүлэгт хоёр дахь явцын тайлангаа хүргүүлснийг мөн оны 05 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд хамгаалах, түүнд бэлтгэх вакум хуралд тус албанаас 1 алба хаагч оролцсон.

Албаны даргын зөвлөлийн хуралдаанаар 2020 онд хэлэлцүүлэх 19 асуудлын төлөвлөгөөг энэ батлуулан хагас жилийн байдлаар ээлжит 4, ээлжит бус 1, нийт 5 удаагийн хуралдааныг зохион байгуулж, нийт 32 асуудлыг хэлэлцсэний 18.8 хувь нь удирдлага зохион байгуулалтын чиглэлээр, 9.4 хувь нь албаны шалгалтын дүнгийн талаар, 71.8 хувь нь хүний нөөцийн чиглэлээр хэлэлцэн, тодорхой шийдвэрийг гаргаж, үр дүнг тооцсон. Албаны даргын А, Б нийт 54 тушаалыг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолыг баримтлан, Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн тус албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар хянуулан баталгаажуулж, эхний хагас жилийн хэрэгжилтийг тооцсон.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын мөн оны 47 дугаар тушаалаар баталсан загвар, аргачлалын дагуу алба хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирал бүр гарган батлуулж, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг сар, улирал бүр тооцон ажиллаж байна.

Тус албаны болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтын төслүүдийг Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолд заасан албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагад нийцүүлэн, боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/153 дугаар тушаалаар батлуулан, алба хаагч нэг бүрд танилцуулан, мөрдөн ажиллаж байна.

Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын экологийн асуудал хариуцсан алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлж, дүгнэхэд харгалзах үзүүлэлт болгох шалгуур үзүүлэлт, ажил дүгнэх хүснэгтийг энэ оны А/13 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын Хужирт сум дахь цагдаагийн тасгийн экологийн асуудал хариуцсан байцаагчийн орон тоог Бат-Өлзий сум дахь цагдаагийн хэсэгт шилжүүлэх саналтай ирүүлсэн материалыг албаны даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжих саналын хамт 16/259 дүгээр албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргад уламжлан хүргүүлж, шийдвэрлүүлсэн.

**Хүний нөөцийн чиглэлээр:** Монгол Улсын Засгийн газрын энэ оны 03 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны А/09 тушаалаар цагдаагийн төв байгууллагын бүтцэд тус албыг байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын мөн оны А/17 дугаар тушаалаар бүтэц, орон тоог баталсантай холбогдуулан хүний нөөцийн нөхөн хангалтыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудаас шилжүүлэн буюу зохицуулалт хийн 41, шинээр 11, нийт 52 алба хаагч, ажилтныг томилуулж, өөрийн хүсэлтээр 2 алба хаагч албанаас чөлөөлөгдсөн.

Тус албаны тусгай мэргэжил, мэргэшил шаардсан зарим албан тушаал дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, зарын дагуу 109 иргэн материал ирүүлснээс шаардлага хангасан 40 иргэний материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, тэнцсэн 11 иргэнийг Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын Б/03 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэн, 8 иргэнийг мэргэжилтэн-дадлагажих ажилтнаар томилуулан “Цагдаагийн байгууллагад ажиллах дадлагажих ажилтантай байгуулах гэрээ”-г байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын болон албаны даргын тушаалаар томилогдсон 3 алба хаагчаар цагдаагийн тангараг өргүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг энэ оны А/11, А/27 дугаар тушаалаар тус тус батлан, тангараг өргүүлэх ажиллагааг зохион байгуулж, мөн оны Б/23 дугаар тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн зөвшөөрлийн дагуу 1 алба хаагчид хугацааны цагдаагийн ахлагч цол олгосон.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шагнаж, урамшил олгох /код-925/ журам”-д заасан болзол шаардлага хангасан 10 алба хаагчийг шагнуулах санал, материалыг холбогдох газарт хүргүүлснээр Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 1, Эрүүгийн цагдаагийн албаны “Баярын бичиг”-ээр 1 алба хаагч тус тус шагнуулсан.

Шинээр томилогдсон алба хаагчдыг албаны бахархал, үнэт зүйлийн талаар мэдлэг олгох, ажлын арга барилд сургаж дадлагажуулах, цагдаагийн албаны онцлогт дасгаж төлөвшүүлэх зорилгоор 46 алба хаагч, ажилтанд албаны даргын тушаалаар халамжлан хүмүүжүүлэгч нарыг томилж, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

**Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хүрээнд тус албанаас энэ онд зохион байгуулах албаны сургалтын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 18 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр, албаны сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг 92 сэдвийн хүрээнд 150 цагийн сургалтыг зохион байгуулахаар тус тус төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран алба хаагчдын мэдвэл зохих хууль, тогтоомж, тэдгээрийг хөгжүүлэх, дадлагажуулах, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг нийт 42 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 2014 алба хаагчийг хамруулсан.

Экологийн асуудал хариуцсан алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх цахим сургалт зохион байгуулах Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны “Сургалт зохион байгуулах тухай” А/250 дугаар тушаалаар баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд сургалтын материалыг видео болон товхимол хэлбэрээр бэлтгэн аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдад хүргүүлэн судлуулах ажлыг зохион байгуулж, 60 асуулт бүхий тестийн шалгалтыг цахим

хэлбэрээр зохион байгуулж, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвтэй хамтран гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулсан.

Хууль сахиулах их сургуулийн Цагдаагийн сургуультай хамтран экологийн асуудал хариуцсан алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй, эрх зүйн орчин” гарын авлагыг бүтээж, экологийн асуудал хариуцсан алба хаагч нарт тараан, үйл ажиллагаанд нь ашиглуулж байна.

“Өнгө нэмцгээе 2020” аяны хүрээнд “Цагдаагийн алба хаагчийн сахилгын болон ёс зүйн дүрэм”, “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох хуулийн зүйл, заалтуудын гарын авлага”-ыг тус бүр 50 ширхгийг хэвлүүлэн, алба хаагчдад тараан өгч, үйл ажиллагаанд нь ашиглуулж байна.

Бие бүрэлдэхүүний дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий “Биеийн тамир, спортын хамтлаг”-ийг албаны даргын энэ оны А/07 дугаар тушаалаар байгуулж, тус хамтлагаас энэ онд зохион байгуулах ажил, арга хэмжээний 24 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийн ханган ажиллаж байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зарим тэмцээн, уралдааныг түр хугацаагаар хойшлуулсан бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу дартс, 100 буудалт даамны аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, алба хаагч, ажилтнуудын бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Сүлд” биеийн тамир, спортын хороотой гэрээ байгуулан, алба хаагчдыг долоо хоног бүрийн Лхагва гарагт спорт зааланд биеийн тамир, спортоор хичээллүүлж байна.

Алба хаагчдын тав тухтай байдлыг бүрдүүлэн, гоо зүйн хүмүүжил, экологийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг ажиллаж, амьдрах орчиндоо цэцэг тарьж, арчилж ургуулах арга технологид сургах, улмаар байгууллагын орчныг цэцэгжүүлэх замаар эрүүл, аюулгүй, таатай орчинг бүрдүүлэх зорилгоор “Эко орчинг бүрдүүлж, эрүүл амьдарцгаая” цэцэгжүүлэлтийн нэг сарын аян, ажилдаа хандах хандлага, урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор “Дурсамж үлдээсэн мөч”, алба, аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын дунд “Би зөв цэвэр бичигтэн”, “Миний ажлын нэг өдөр” фото зургийн уралдаан, алба хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдааныг тус тус зохион байгуулсан.

**Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:** Улсын Ерөнхий прокурорын 2017 оны “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” А/67 дугаар тушаалд тус албаны шалгах хэргийн харьяаллыг нэмж тусгуулах саналыг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 01/104 дүгээр албан бичгээр Улсын ерөнхий прокурорын газарт хүргүүлснээр Улсын Ерөнхий прокурорын “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” энэ оны А/33 дугаар тушаалаар “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг тус албанд харьяалуулах” гэж тусган батлуулсан.

Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэг /Байгаль орчин амьтан ургамлыг хамгаалах журмын эсрэг/-т заасан зарим төрлийн зөрчлийг Экологийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтэс шалган шийдвэрлэх талаар хуулийн төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл энэ оны 05 дугаар сарын 20-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар орж дэмжигдсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 100, 101, 123, 124, 133, 136, 201, 227, 306, 325, 327, 409, 721, 924/-д тус албаны үйл ажиллагааг зохицуулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах саналыг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэст хүргүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/20, А/44, А/45 дугаар тушаалуудаар нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан.

Шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, эрх зүйн акт 25 ирснийг алба хаагч нэг бүрд танилцуулж, дотоод сүлжээний “Сургалтын цахим сан”-д байршуулан,

онлайнаар ашиглах боломжийг бүрдүүлж, дээд шатны байгууллагаас санал авахаар ирүүлсэн 17 журам, 3 төлөвлөгөө, 4 хуулийн төслийг алба хаагчдаар хэлэлцүүлж, гарсан саналыг тусгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэст хүргүүлсэн.

Мөн Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан 79 байцаагчид Улсын байцаагчийн эрхийг олгуулах ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлтийг 16/234 дүгээр албан бичгээр Улсын ерөнхий прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст, Улсын байцаагчийн эрхийг олгох хүсэлтийг 16/235 дугаар албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

**Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр:** Алба хаагчдаас баримтлах ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчийн нэр төрийг хамгаалах чиг үүрэг бүхий орон тооны бус “Ёс зүйн зөвлөл”-ийг албаны даргын энэ оны А/22 дугаар тушаалаар байгуулж, тус зөвлөлөөс энэ онд хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангаж, тус албаны болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээг сар бүр нэгтгэн, дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр 1 цагийн цахим сургалтыг зохион байгуулж, 45 алба хаагчийг хамруулан, “Хэрвээ би удирдах түвшний шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан байсан бол алба хаагчдын сахилга, ёс зүйг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээ” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг албаны зохион байгуулалтын нэгжүүд болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын дунд зохион байгуулж, шалгарсан алба хаагчдыг шагнаж урамшуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ээр өврийн дэвтэр хийж, алба хаагчдад тараан өгч, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/57 дугаар тушаалаар баталсан загварын дагуу 52 алба хаагчтай “Итгэлцлийн гэрээ”-г байгуулж, Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийг болон бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах чиглэлээр зааварчилга 2, зөвлөмж 1, 5 төрлийн баталгааг давхардсан тоогоор 187 алба хаагчаас авсан.

Мөн албаны 1 дүгээр улирлын сахилгын зөвлөгөөнийг аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, мөрдөгч нарыг хамруулан цахимаар зохион байгуулж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс зохион байгуулж буй “Өнгө нэмцгээе-2020” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас зохион байгуулсан “Хувь хүний төлөвшил”, Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан “Хорт зуршил-Эрүүл бие” аяны хүрээнд тодорхой ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулж, дүнг нэгтгэн, нотломжийн хамт хариуцсан албадад хүргүүлсэн.

Мөрдөн байцаах албанаас зохион байгуулж буй “Хуульч ажиллагаа” арга хэмжээний хүрээнд алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтуудыг тогтмол зохион байгуулан, холбогдох материалаар гарын авлага бэлтгэн өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд нь ашиглуулж байна.

**Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хоёр дахь үе шатны төлөвлөгөө”-ний хүрээнд 5 зорилтын хүрээнд 30 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр салбар төлөвлөгөө гарган, эхний хагас жилийн хэрэгжилтийг 91.3 хувьтай хангаж, 16-1/964 дүгээр албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Мөн тус албаны хэмжээнд Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, зөвлөлөөс гаргасан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 8 хүний бүрэлдэхүүнтэй салбар зөвлөлийг албаны даргын А/25 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан “Цагдаагийн алба хаагчид хориглох зүйл”, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд заасан “Хориглох зүйл”-ийг өдөр тутмын ажилдаа баримтлан, сахиж ажиллах тухай 8 заалт бүхий, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас гаргасан “Зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 10 дахь заалтыг хангах ажлын хүрээнд 4 заалт бүхий баталгааг нийт 48 алба хаагчаас гаргуулан авч, хяналт тавин ажиллаж байна.

**Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар:** Тайлангийн хугацаанд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2, алба хаагчдаас удирдах албан тушаалтанд нийт 41 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирүүлсний 40 буюу 97.6 хувийг шийдвэрлэж, 1 буюу 2.4 хувь нь хуулийн хугацаанд байна.

**Архив, бичиг хэргийн үйл ажиллагааны чиглэлээр:** Дээд шатны байгууллага болон бусад алба, газар, хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагаас бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр давхардсан тоогоор нийт 690, үүнээс хугацаатай 221, энгийн 469 албан бичгийг хүлээн авч, удирдлагын заалт бичүүлэн холбогдох албан тушаалтанд шилжүүлж, алба хаагчдаас төслөөр ирсэн 415 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандарт, Монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй бичиж, хэвлэмэл хуудсанд буулгаж ажилласан.

Мөн нийт 113 үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, зөвлөмжийг хүлээн авч, биелэлт, үр дүнг тооцон, холбогдох газарт хүргүүлж, алба, хэлтсийн дарга нараас 19 удаагийн үүрэг, ажлын чиглэлийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлсэн.

Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дууссан хэргийг архивд шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг энэ оны А/15 дугаар тушаалаар байгуулж, тус албаны 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталж, Цагдаагийн ерөнхий газрын Төв архивд хүргүүлэн хянуулсан.

### **Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар**

Тус албанаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаа.

**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:** Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Нийслэлийн байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Туул голын сав газрын захиргаатай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монголын бичил уурхайн нэгдсэн “Дээвэр” холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Иргэн бүрд байгаль дэлхийгээ шүтэн хамгаалж, байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн үндэсний өв уламжлалаа шинжлэх ухаан, инновац, технологийн ололтод тулгуурлан бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор 2020-2023 онд хэрэгжүүлэх “Иргэн бүрт экологийн боловсрол” төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Монголын байгаль орчны иргэний зөвлөл” төрийн бус байгууллагатай хамтран боловсруулж, байгаль, зэрлэг амьтан хамгаалах “Хүрээлэн төсөл”-ийн багтай хамтран “Шонхор” эко боловсролын хөтөч цуврал нэвтрүүлгийн эхний 3 дугаарыг бэлтгэн иргэд, олон нийтэд түгээх зөвшөөрөл авахаар Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргад танилцуулсан.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ 6, олон нийтийн ухуулга, нөлөөллийн 2 аяныг зохион байгуулж, үр дүнг тухай бүр тооцон ажилласан.

Тухайлбал, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Мөрдөн байцаах алба, Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-тай хамтран “Таны дуу хоолой байгалийг хамгаалж чадна” уриа дор “Ногоон дуу хоолой” нөлөөллийн аяныг энэ оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 1 сарын хугацаанд зохион байгуулж, телевизийн “Зочны цаг”, “Өглөө” нэвтрүүлэг, “Тодруулга” буланд 10 удаагийн ярилцлага, 12 сурвалжилга мэдээ өгч, сайтад ярилцлага 7, мэдээ, нийтлэл 14, лайв 2, подкаст 2-ыг бэлтгэн давхардсан тоогоор 36 сайтад 104 удаагийн мэдээ мэдээлэл, нийтлэл өгч, FM радиогоор цагийн мэдээ 4340, шторк 2790, нэвтрүүлэг 60 удаа эфирт цацагдаж, 56,000 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, ухуулгын хуудас бэлтгэн тарааж, видео шторк 15, бүтээлч 47 постер бэлтгэн байршуулж, олны танил 24 хүнийг аянд нэгдүүлэн уриалга гаргуулан нийтийн цахим сүлжээнд байршуулснаар 24,087 хүнд таалагдаж, 26,715 удаа хуваалцаж, 2,160 сэтгэгдэл үлдээж нийт давхардсан тоогоор 5,603,909 хүнд хүрсэн.

Мөн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээс офицер 1160, ахлагч 1088, олон нийтийн цагдаа 591, нийт давхардсан тоогоор 2839 алба хаагч, 429 төрийн, 159 төрийн бус байгууллага, 587 аж ахуй нэгж, иргэнтэй хамтран 42 удаагийн хяналт, шалгалтыг зохион байгуулж, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн шинжтэй 119, зөрчлийн шинжтэй 140 үйлдлийг илрүүлэн, 232 зөрчлийг газар дээр нь шийдвэрлэж, 8007 иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгч, давтан зөрчил гаргасан 90 иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцож, 215 мэдэгдэл, шаардлага хүргүүлэн, мэдэгдлийн мөрөөр газар дээр нь 203 удаагийн шалгалт хийж, 157 хариуг авсан.

“Байгаль Эн Тэргүүнд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэд, олон нийтэд хог хаягдлын талаар мэдээлэл өгөх, хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг бууруулах, экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн буруу дадал хандлагыг өөрчлөх, соёлыг төлөвшүүлэх, зөв үйлдэлд уриалах, эерэг өөрчлөлт гаргах чиглэлээр “Хогоор бүү хорло” нөлөөллийн аяныг зохион байгуулан ажиллаж байна.

Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шуурхай шалгаж шийдвэрлэх зорилгоор “Ой хээрийн түймэр” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, орон нутгийн Онцгой байдлын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалтын газар болон нутгийн иргэдийн хамт нийт 39 удаагийн эргүүл, шалгалтыг 1019 хүн, хүчтэйгээр зохион байгуулан ажилласнаар энэ төрлийн гэмт хэргийн гаралт 44.4 хувиар буурч, илрүүлэлт 8.9 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Агнуурын загасны нөөц хомстож, устахаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 сарын хугацаатай “Загас хамгаалал 2020” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, 360 удаагийн хяналт шалгалтаар 4957 хүн, 1926 эд зүйл, 2875 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, тусгай хамгаалалттай газарт загас агнасан гэмт хэрэг 3, хориглосон хугацаанд загас агнасан зөрчил 24, бусад төрлийн 18, нийт 3 гэмт хэрэг, 42 зөрчил илрүүлж, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон орлогыг холбогдох журмын дагуу хураан авч ажилласан.

Нийслэлийн ногоон бүсээс хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн байгаль орчны газартай хамтран “Ойн эргүүл” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан 1064 километр газар нутагт хяналт шалгалт хийж, модон материалын худалдаа үйлчилгээний цэг 1, Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх 2 постын үйл ажиллагааг шалгаж постоор нэвтэрсэн 6 тээврийн хэрэгсэл, 47 хүнд үзлэг, шалгалт хийсэн.

“Ус ба уур амьсгалын өөрчлөлт” сэдвийн хүрээнд энэ оны 03 дугаар сарын 22-ны өдөр “Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор усны зохистой хэрэглээний чиглэлээр ухуулга, нөлөөллийн зурагт хуудас 32, богино хэмжээний видео бичлэг 26-г цахим орчинд түгээж, “Витафит групп” ХХК, “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо”-той хамтран Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, 4 дүгээр хэсэг, уулын зам дагуу иргэдийн амралт зугаалгын газарт 5.0 сая төгрөгийн өртөг бүхий тохижилтын ажил хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Цахимд сүлжээнд байршуулсан мэдээллүүд Монгол Улсад 662.000, гадаад улсад 424.447 хүнд хүрсэн байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд цэвэр усны нөөц хомсдож байгаа, бохирдол бодитой болсон, усны ухаалаг бус хэрэглээтэй болсон, устай харьцах уламжлал алдагдсан гэх мэт устай холбоотой тулгамдсан асуудлыг хөндсөн зорилгод сэдвийн хүрээнд салбарын

эрдэмтэн судлаачдын үзэл бодол, өнцгийг тусгасан 7 минутын видео нэвтрүүлгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн дэмжлэгтэй бүтээн иргэд, олон, нийтэд хүргэсэн.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр албаны Фэйсбүүк, Инстаграмм, Твиттер цахим хаягт алба хаагчдын илрүүлсэн гэмт хэргийн мэдээ 360, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл 720, танин мэдэхүйн 885, бусад 469, нийт 2434 мэдээ, мэдээллийг нийтэлсэн. Мөн 169 телевиз, 189 сайт, 56 сонин, сэтгүүл, 84 фм, радиотой хамтран ажилласнаар давхардсан тоогоор 62 нэвтрүүлэг, ярилцлага, 186 сурвалжилга, мэдээ, мэдээлэл нийтэлж, иргэд олон нийтэд хүргэсэн.

**Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр:** Улсын хэмжээнд энэ оны эхний хагас жилд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 886 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс бүртгэгдсэн гомдол 556-аар буюу 1.8 дахин өссөн байна.

Гомдол, мэдээллийн 51 буюу 5.7 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хуулийн хугацаанд байна. Үүнээс 47 буюу 92.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 4 буюу 7.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байгаа ба гэмт хэргийн шинжтэй 593, зөрчлийн шинжтэй 242 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг энэ оны эхний хагас жилд нийт 385 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 152 хэрэг буюу 65.2 хувиар өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн 13943 хэргийн 2.8 хувийг эзэлж байна. Энэ төрлийн хэргийн илрүүлэлт 39.8 хувьтай байгаа нь өмнөх онд 44.0 хувьтай байснаас 4.2 хувиар буурсан.

Бүртгэгдсэн 385 хэргийн 351 буюу 91.2 хувь нь орон нутагт, 34 буюу 8.8 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад орон нутагт бүртгэгдсэн хэргээр 141 хэрэг буюу 67.1 хувиар, Улаанбаатарт бүртгэгдсэн хэрэг 11 хэргээр буюу 47.8 хувиар тус тус өссөн.

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хөнгөн гэмт хэрэг 218 байснаас 371 болж 116 хэргээр буюу 70.2 хувиар өсөж, хүнд гэмт хэрэг 15 байснаас 14 болж 1 хэргээр буюу 6.7 хувиар буурсан байна.

Хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгасан 324 хэргийн 129 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсанаар хэргийн илрүүлэлт 39.8 хувьтай, өмнөх онд 44.0 хувьтай байснаас 4.2 хувиар буурсан. Хэргийн илрүүлэлтийг ангиллаар авч үзвэл: хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 40.2 хувьтай, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 30.8 хувьтай байна.

Улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн улмаас нийт 280 иргэн, 17 хуулийн этгээдэд 2.640.367.688 төгрөгийн хохирол учирснаас 885.881.445 төгрөгийг буюу 33.6 хувийг нөхөн төлүүлж, 535.939.143 төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 2.640.367.688 төгрөгийн хохирлын 33.6 хувийг нөхөн төлүүлсэн нь нөхөн төлөлт урьд оноос 6.8 хувиар өссөн үзүүлэлттэй.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал”-ийн 1.8.6.8 дахь хэсэгт цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгах эрхтэй талаар заасан бөгөөд энэ оны эхний хагас жилд Зөрчлийн тухай хуулийн 7.15.8 дахь хэсгээр улсын хэмжээнд 58 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 52 зөрчил буюу 8.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох дүгнэлтгүй талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор 18 удаагийн хяналт шалгалтын ажиллагаа явуулж, Ашигт малтмал, газрын тосны газраас гаргасан дүгнэлтгүй талбайд ашигт малтмал олборлосон 4 нөхөрлөл, 63 иргэний хууль зөрчсөн үйлдэлд хэрэг бүртгэлтийн 34 хэрэг нээн, холбогдох шалгалтыг явуулж, 6 нөхөрлөлийн үйл ажиллагааг бүрэн зогсоосон.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын энэ оны А/137 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг болон тус алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас баталсан удирдамжийн хүрээнд ойн сан бүхий газарт 25 удаагийн хяналт шалгалт явуулж, 422 аж ахуйн нэгж,

нөхөрлөлийг шалгаж, хууль бусаар мод бэлтгэсэн 9 гэмт хэрэг, 138 зөрчлийг илрүүлэн харьяаллын дагуу холбогдох газруудад шилжүүлсэн.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр эргүүл хяналт шалгалтыг давхардсан тоогоор 124 цагдаагийн алба хаагч, 62 байгаль орчны улсын байцаагч, 46 тээврийн хэрэгсэлтэйгээр зохион байгуулж, 12 холбогдогчтой, 78.0 сая төгрөгийн хохиролтой 7 хэргийг шинээр илрүүлэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагааны явцад нэн ховор амьтан болох цоохор ирвэсийн арьс 7, хотон шувууны хошуу 12, ховор амьтан болох хүрэн баавгайн арьс, савар 18, амьтны соёо 20, янгир ямааны эвэр 4, галт зэвсэг 8-ыг тус тус хураан авсан.

Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Увс, Төв, Ховд, Хэнтий аймаг дахь цагдаагийн газраас Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газруудтай хамтран 7 цэгт байнгын постыг ажиллуулж, 1200 орчим иргэн, 852 тээврийн хэрэгслийг шалган, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хариуцлага тооцох, учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх зорилгоор Нийслэлийн байгаль орчны газартай хамтран “Түгээмэл-2020” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулж, зөрчилтэй 23, тусгай зөвшөөрөл цуцлагдсан 2 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлэн харьяа дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсүүдэд шилжүүлэн ажилласан.

Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Туул, Улиастай гол орчмын усан сан бүхий газар машин техник, бохир зүйл угаасан 46 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар 4.6 сая төгрөгийн шийтгэл оногдуулсан.

**Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд:** Дэлхийн олон улсад шинэ төрлийн коронавирусийн тархалт буурахгүй байгаатай холбогдуулан хүн амыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирусийн халдварын цаг үеийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг тухай бүр алба хаагчдад танилцуулан, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас гаргасан сэрэмжлүүлэг, зөвлөмжүүдийг хэвлэн өрөөнүүдэд байршуулан, хэрэгжилтийг хангаж, алба хаагчдыг ажилдаа ирэх үед биеийн халууныг хэмжин, маск зүүсэн эсэхийг шалган, гарын үсэг зуруулан ажлын байранд нэвтрүүлж, өдөр бүр илчлэг халуун аарц, чацаргана, аньсны шүүсээр үйлчлэн, нэг удаагийн амны хаалт тараан өгч, гар ариутгах төхөөрөмжийг албаны бүх өрөөнд байрлуулж, 2 цаг тутам санитас бодисоор гараа ариутгах боломжийг бүрдүүлэн, 7 хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гарагуудад зориулалтын бодисоор өрөөнүүдэд ариутгал халдваргүйжүүлэлт хийж хэвшсэн.

Халдварт өвчний тохиолдлоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор хуваарилагдсан хөдөлмөр хамгааллын зардлын төсвөөр гар ариутгагч 67, автомакс 3, ариутгалын бодис 9, ариутгалын спирт 110, нэг удаагийн бээлий 1040, малгай 368, маск 920, маск /N95/ 88, улавч 344, хамгаалалтын хувцас 118, хөдөлгөөн хязгаарлагч том 1, хөдөлгөөн хязгаарлагч жижиг 1, нүдний шил 110, нүүрний хаалт 110, 1 халуун хэмжигчийг тус тус худалдан авч, бэлэн байдлыг хангасан.

Нийслэлийн ерөнхий боловсролын 105 дугаар сургуулийн хамт олноос тус албанд хандивласан 1.0 сая төгрөгөөр алба хаагчдын дархлааг дэмжих амин дэм, байр, өрөө тасалгааны ариутгал халдваргүйжүүлэлт хийх бодис, албаны гэнэтийн болон шаардлагатай үед хэрэглэгдэх эмнэлгийн анхны тусламжийн хайрцаг, хэрэгсэл, эм бэлдмэлүүдийг худалдан авсан.

Улсын онцгой комиссын шийдвэрээр гадаад улсаас 3 удаагийн татан авалтаар Монгол Улсын 183 иргэнийг Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Цэлмүүн трейд” ХХК-ий “Дрийм-1, 2” зочид буудалд байрлуулж, тусгаарлан ажиглах үеийн гадна хамгаалалтад тус албанаас давхардсан тоогоор нийт 114 алба хаагч, 2736 хүн цагийн үүрэг гүйцэтгэж, нөхцөл байдлын талаар тухай бүр Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга болон Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргад танилцуулж ажилласан.



Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үеэр Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт санал авах байрны орчимд 35, Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Хэнтий аймагт 4, нийт 39 алба хаагч нэмэгдлээр үүрэг гүйцэтгэж ажилласан.

Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед Цагдаагийн ерөнхий газрын III байрны аюулгүй байдлыг хангах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгууллагын эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх үеийн төлөвлөгөөг боловсруулан тус байранд үйл ажиллагаа явуулж алба, хэлтсийн дарга нараар батлуулж, алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангах, сахилга хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор 2 зааварчилгаа өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

**Мэдээлэл судалгааны чиглэлээр:** Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас нэгтгэн гаргасан статистик мэдээн дээр тулгуурлан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын танилцуулга, цагаан мэдээг сар бүр өссөн дүнгээр нэгтгэн гаргаж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2019 онд шүүхээр шийдвэрлэгдсэн хууль бусаар ан агнах, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж байсан амьтны нэр, эд эрхтэн, хууль бусаар түүж, бэлтгэсэн, ашигласан ургамал, ургамлын үрийн талаарх судалгааг 13 аймаг, 32 сум, дүүргээс авч нэгтгэн, Байгаль орчны захиргааны статистикийн БОХ-4.4а маягтын дагуу Байгаль орчны мэдээллийн сан /<https://eic.mn/box/>-д шивж оруулсан.

Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн санд шивэгдсэн 251 маягтыг нэг бүрчлэн хянаж, 87 маягтыг шаардлага хангаагүй төлөвт буцаан, засварлуулж, “Эрүүгийн хариуцлага, хүлээлгэсэн хүн хуулийн этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа олгох /код 706/ журам”-ын дагуу 352 иргэний эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэхийг шалгаж, лавлагаа олгон, бүртгэл хөтөлсөн.

**Мэдээллийн технологи, холбооны чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас олгосон Hytera TC-580V маркийн 30 ширхэг хэт богино долгионы гар станц, Body born m505 маркийн 30 ширхэг энгэрийн камер, Samsung tab active маркийн 6 ширхэг таблет, Samsung galaxy XCover4 маркийн 11 ширхэг гар утас, Dell inspiron-15 3000 маркийн 4 ширхэг зөөврийн компьютер, Samsung M2070, Epson L1800, 3110 маркийн нийт 9 ширхэг принтер, Mavic air2 маркийн дрон /алсын удирдлагатай камерын төхөөрөмж/, Nikon D750, Canon eos M10 маркийн зургийн аппарат, сүлжээний свитч 12, телефон аппарат 2 ширхэг, нийт 12 нэр төрлийн 138 тоног, төхөөрөмжийн бүртгэл, суурилуулалт, холболт, тохиргоог хийж ажилласан.

Мөн алба хаагчдын компьютер, техник хэрэгсэл, сүлжээний үйл ажиллагаатай холбоотой 373 удаагийн засвар, үйлчилгээг хийж, хэвийн үйл ажиллагааг хангасан.

Нийт 11 аймаг дахь цагдаагийн газрын 65 экологийн асуудал хариуцсан байцаагчийн албан хэрэгцээний компьютерын болон Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд “DirectAccess” системээр холбогдсон талаарх судалгааг, авч нэгтгэн, холбогдох газарт саналыг хүргүүлж, 39 сумын байцаагчийн ажлын байрыг Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд “DirectAccess” системээр холбох ажлыг зохион байгуулсан.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 30 ширхэг компьютерыг Цагдаагийн байгууллагын нэгдсэн Domain /Isolation network/ сүлжээнд холбон, олон нийтийн цахим сүлжээнд хандах 8 эрхийг Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн алба хаагчдад олгож, Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд байршуулсан лицензлүүлсэн Windows 8, Windows 10 үйлдлийн системийг 12, лицензтэй “Microsoft office” хэрэглээний программыг 52 алба хаагчийн компьютерт суулгаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж, файл менежмент “Police cloud” системийг хэрхэн ашиглах, Дотоод цахим шуудан /Outlook/-г архивлах заавар, зөвлөмжийг алба хаагчдад танилцуулан, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

### **Гурав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар**

Тус албанд энэ оны хагас жилийн төсвийн урсгал санхүүжилтийн зардалд 598.6, үүнээс 322.5 сая буюу 53.8 хувь нь цалингийн, 277.0 сая буюу 46.2 хувь нь урсгал зардал бөгөөд Санхүү, аж ахуйн албанаас үндсэн хөрөнгө 264.0, бараа материал 37.8 сая төгрөгийн хөрөнгө материалыг шийдвэрлүүлэн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Энэ оны 1 дүгээр улиралд дотоод албан томилолтын зардал хүрэлцэхгүй байсантай холбогдуулан 2 дугаар улирлын төсөвт нэмүүлэх хүсэлтийг 16/40 дүгээр албан бичгээр

Санхүү, аж ахуйн албанд хүргүүлж, 4.3 сая төгрөгийг 6 дугаар сарын төсөвд нэмүүлэн, хагас жилийн байдлаар өр, авлагагүй ажилласан.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний санхүүжилт 48.0, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Байгаль Эн Тэргүүнд” нэгдсэн арга хэмжээний санхүүжилт 20.0 сая төгрөг тус албаны нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлснийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан.

Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Шилэн дансны нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.shilendans.gov.mn> болон тус албаны [ecological.police.gov.mn](http://ecological.police.gov.mn) цахим хуудсанд төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад санхүүгийн холбогдолтой нийт 69 мэдээ, мэдээллийг тухай бүр тогтоосон хугацаанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Албаны эд хөрөнгийн 2020 оны эхний хагас жилийн тооллого явуулах Ажлын хэсгийг албаны даргын энэ оны А/24 дүгээр тушаалаар байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хадгалалт, эзэмшилт, хаягжуулалт, эмх цэгц, зарцуулалт, чанар байдалд хяналт тавьж, эдэлгээний хугацааг тодорхойлох ажлыг зохион байгуулж, дүнг Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж ажилласан.

**Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр:** Албаны албан ажлын хэрэгцээнд шаардлагатай байгаа автомашиныг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 01/152 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн, туулах чадвар сайтай 1 автомашиныг шийдвэрлүүлсэн.

Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороонд байрлах Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын мэдэл дэх 12 дугаар байрыг Цагдаагийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт уламжлан шийдвэрлүүлж өгөх хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын энэ оны 02/186 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлж, уг даргын энэ оны 1-4/1829 дүгээр албан бичгээр уламжлуулан хүргүүлсэн.

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2020 онд зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөгөө гарган, тэдгээрийн амьдрал ахуйтай танилцаж, нийгмийн баталгааг хангах, ажил, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх зорилгоор 36 алба хаагчийн ар гэртэй танилцаж, тэдний санал хүсэлтийг сонсож ажилласан.

Мөн алба хаагчдын нийгмийн асуудлыг тодорхойлох зорилгоор судалгаа авч нэгтгэн, ипотекийн зээлд 5, түрээсийн орон сууцны хөтөлбөрт 3 алба хаагчийг хамруулах хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст, нийслэлийн ногоон бүсэд зуслангийн газар олгуулах ажилд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг энэ оны 16/888 дугаар албан бичгээр Нийслэлийн байгаль орчны газарт тус тус хүргүүлсэн.

**Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:** Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах “Эрүүл цагдаа” хөтөлбөрийг албаны хэмжээнд хэрэгжүүлэх салбар төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг тооцож, 16/981 дүгээр албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн, осолд өртөж хохирсон, амь насаа алдсан цагдаагийн алба хаагчдыг судлан бүртгэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг албаны даргын энэ оны А/09, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий орон тооны бус “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийг А/21, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг А/20 дугаар тушаалаар тус тус томилсон.

Алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах зорилгоор Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулж, энэ оны 04

дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар 3 алба хаагч өдрийн эмчилгээ хийлгэсэн.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжих зорилгоор “Нэг сэтгэл, нэг хамт олон” аяныг энэ оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулж, хуваарийн дагуу 20 удаа давхардсан тоогоор 246 алба хаагчид өдөр бүр илчлэг халуун аарц, чацаргана, аньсны шүүсээр үйлчлэн, витаминжуулалтын аяныг өрнүүлэн алба хаагчдын дархлааг сайжруулах, өвчлөлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор вакус, С, Е витамин тараан өгч ажилласан.

Мөн эрүүл, аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх зорилгоор “Эко орчинг бүрдүүлж, эрүүл амьдарцгаая” цэцэгжүүлэх аяныг энэ оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулж, дүгнэсэн.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын сэтгэл зүйчдийн багтай хамтран алба хаагчдаас сэтгэл зүйн сорил авч, сорилын дүгнэлтэд тулгуурлан 17 алба хаагчид ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.

Нийслэлийн ерөнхий боловсролын 105 дугаар сургуулийн хамт олноос тус албанд хандивласан 1.0 сая төгрөгөөр алба хаагчдын дархлааг дэмжих амин дэм, байр, өрөө тасалгааны ариутгал халдваргүйжүүлэлт хийх бодис, албаны гэнэтийн болон шаардлагатай үед хэрэглэгдэх эмнэлгийн анхны тусламжийн хайрцаг, хэрэгсэл, эм бэлдмэлүүдийг худалдан авч, тус сургуулийн захиралд албаны даргын “Талархал”-ыг гардуулан өгч, Цагдаагийн ерөнхий газрын [www.police.gov.mn](http://www.police.gov.mn), албаны [ecological@police.gov.mn](mailto:ecological@police.gov.mn) цахим хуудсаар иргэд, олон нийтэд хүргэсэн.

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБА